



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

Салбар зөвлөлийн
гишүүнийг чөлөөлж, томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4, 5.12 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Салбар зөвлөлийн гишүүнээс Виз, зөвшөөрөл, харьяатын газрын дарга Ч.Нармандах, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтсийн дарга Л.Батсүх, Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн дарга Ч.Тулгацоодол, Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга Б. Даваажав нарыг чөлөөлсүгэй.

2.Тус Салбар зөвлөлийн гишүүнээр Зөрчил шалган шийдвэрлэх газрын дарга Х.Бэхбат, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтсийн дарга З.Өнөрсайхан, Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Солонго, Агаарын замын боомт хариуцсан газрын дарга З.Даваасүрэн нарыг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөс томилсугай.

3.Төрийн албаны тухай хууль тогтоомж, “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Салбар зөвлөлийн гишүүдийг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж буй байдалд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Салбар зөвлөлийн дарга (Н.Ууганбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ